



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 04

Аргайхээр

Салбар комисс байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын 3.1, 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны ерөнхий шалгалт зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар комиссын дарга: Ц.Ганболд -аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Салбар зөвлөлийн дарга
Гишүүд: Т.Гончигдорж -аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн
Н.Энхцэцэг -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн
Б.Сайнжаргал -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн
А.Отгонцэцэг -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн
С.Дуламсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга, Салбар зөвлөлийн гишүүн
Т.Үржинпүрэв -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн
Н.Чимэддорж-Ойдов -аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн
Э.Бадамгэрэл -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

2. Шалгалт зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө, салбар комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарийг тус тус батлуулахыг Салбар комиссын нарийн бичгийн дарга (Э.Бадамгэрэл)-д даалгасугай.

3. Төрийн албаны ерөнхий шалгалтыг холбогдох журам, Төв комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу зохион байгуулж, шалгалтын тайлан, холбогдох материалыг хугацаанд нь хүргүүлэхийг Салбар комисст үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ГАНБОЛД

013100007

D:My Doc.togtool TAZ